

АГУУЛГА

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	9
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	18
БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИЛЖИЛТ, ТАЛХАГДАЛ, ЦӨЛЖИЛТ	35

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа 2050”-д манай орны өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээнд хөгжлийн давуу тал “Бэлчээрийн мал аж ахуй” гэж тодорхойлсон. Энэ давуу талдаа түшиглэн хөгжлийн боломж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ тодорхойлоход:

- Монголын нүүдлийн соёл иргэншлийн өвийг баяжуулан хөгжүүлж, дэлхийд соёл урлагийн бүтээл туурвин таниулж, орлого олох;
- Өргөн уудам нутаг дэвсгэр, бэлчээрийн мал аж ахуй, органик газар тариалан эрхэлж, хүнсээ дотоодын үйлдвэрлэлээс бүрэн хангах чадавх;
- Байгалийн ургамал, малын түүхий эдээр төрөл бүрийн эм, биотехнологи, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох;
- Монголчуудын үндэсний нэгдмэл үнэт зүйл бол “нүүдэлчдийн соёлын үндэс” гэсэн ба дэлхийд ховор мал аж ахуйд суурилсан нүүдэлчин соёл, түүний унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн өвөрмөц байдал, олон угсаатны бүлгүүдийн зэрэгцэн орших сонирхол татам соёлын илрэлүүд гэжээ.

Харьцангуй эрүүл, өргөн уудам бэлчээртээ байгалийн унаган төрхийг нь алдагдуулалгүй өнө удаан жил бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн цөөхөн орны нэг Монгол улсын хувьд өөрийн орныхоо иргэдэд төдийгүй тогтвортой бүтээгдэхүүнд

өндөр үнэ өгөх хилийн чанад дахь хэрэглэгчдэд байгалийн бэлчээрт тулгуурласан бараа, үйлчилгээг тогтвортой нийлүүлэх сайхан боломж байгаа юм.

Монгол улсад мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд тулгарч буй үндсэн асуудал бол бэлчээрийн бүтээмж, биологийн олон янз байдлыг тэтгэдэг бэлчээрийн экосистемийн төлөв байдал, орчны нөхцөл олон газар буурч байгаа явдал юм. Байгалийн бэлчээрийн талхагдал, цөлжилт сүүлийн 30 гаруй жилийн турш эрчимтэй явагдаж байна. 2014 оноос эхлэн Ус, цаг уурын улсын сүлжээний баг бүрт байрлах бэлчээрийн төлөв байдлын мониторингийн 1516 зогсоол цэгт Монгол орны бэлчээрийн төлөв байдлын хандлагыг тодорхойлох судалгаа хийгдэж байна. Бэлчээрийн төлөв байдлын лавлагаа мэдээллийн санг 2014 онд бий болгосон ба гурван жил тутам бэлчээрийн төлөв байдлын хандлагыг гаргасан бөгөөд 2014 оны суурь мэдээлэлтэй харьцуулахад 2018 онд доройтсон бэлчээрийн хувь хэмжээ 65%, эрүүл соргог бэлчээрийн эзлэх хувь хэмжээ 10%-иар буурч, хүчтэй доройтож цөлжих аюулд хүрсэн бэлчээр нутгийн хэмжээ 13% болж нэмэгдсэн нь аюулын харангын дохио гэлтэй. 2018 оны байдлаар, ургац 20-30 хувиар буурч, ургамлын зүйлийн бүрдэл цөөрч, малд идэмжтэй, тэжээллэг үетэн болон алаг өвст бэлчээр хумигдаж, шарилжит, нэг наст ургамлын эзлэх хувь ихэсч байна.

Бэлчээрийн доройтлын 49% нь хүний үйл ажиллагаа, 51% нь байгалийн хүчин зүйлээс үүдэлтэй гэж судлаачид үздэг. Цөлжилтийг эрчимжүүлэхэд хүргэж байгаа нэг хүчин зүйл нь олон жилийн турш бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглаж, талхлагдалд оруулж байгаа явдал юм. Бэлчээрийн зохицуулалтгүй хэт ашиглалт нь байгалийн ургамалд нөхөн төлжих хугацаа, боломж олгохгүй хомсдох, улмаар устахад хүргэж байна.

Бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаан нь нийтийн ашиглалттай бэлчээр дээр хувийн мал аж ахуй эрхэлж байгаа өнөөгийн нөхцөлд энэ харилцааны эрх зүйн хэм хэмжээг тогтоогоогүй байгаатай холбоотой юм. Шинжлэх ухаанд энэ тохиолдлыг “нийтийн эзэмшлийн эмгэнэл (Tragedy of the commons)” гэж нэрийддэг. Үүнийг орчин цагт “Хардины онол” хэмээн нэрлэх болсон бөгөөд уг онолоор нийтийн нөөц /common resources/ нь бүх хүн хэрэглэж болохоор нийтэд нээлттэй /open access/, хэрэглээний төлбөргүй, тодорхой хариуцагч байхгүй тул хязгааргүй хэрэглээ /overuse/ үүсдэг бөгөөд энэ нь “нийтийн эзэмшлийн эмгэнэл”-г бий болгодог хэмээн тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, “бусдад болон байгаль орчинд үүсэх сөрөг үр дагавраас үл хамааран зөвхөн ашиг сонирхлын үүднээс өөрийн үйлдлийг зөвтгөх хандлага”-аар тайлбарлагдана. Тодруулбал, малчин, мал бүхий этгээд нь нийтийн нөөц болох бэлчээрийг ашиглах нь өөрсдийн эдийн засгийн хэрэгцээгээ хангаж буй хэдий ч бэлчээрийг хариуцлагагүй ашигласнаар тухайн бэлчээрийг сүйтгэх ба эргээд өөрсдөө хохирох нөхцөл байдлыг “Нийтийн эзэмшлийн эмгэнэл” буюу “бэлчээрийн доройтол”-той холбон тайлбарлаж болно.

Үүнийг шийдвэрлэх хүрээнд малчдыг бэлчээр нутагтаа өөриймсөг хандах, зүй зохистой ашиглах, бэлчээр ашиглалттай холбогдох хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Уламжлалт заншлын хэм хэмжээний хүрээнд малчид нь шинэ бэлчээр тахлах, тогтоосон бэлчээрийн “хил”-ийг зөрчихийг цээрлэх, нэг газрын цараа нүнжгээ барахаас нааш солихгүй байх, “бүтэн” бэлчээрийг гол нөөц гэж үздэг уламжлалтай байжээ. Бэлчээрийн хил хатуу тогтоогдсон хуваарьтай байсан бөгөөд малын хээл томроогүй үед уулын орой хавийн бэлчээрийг, малын хээл томорсон буюу мал төллөсөн үед

уулын оройгоос доош болон бэл, сугын бэлчээрийг, өвөлжөөний ойрын аргамжааны болон чөдрийн морь, төлөг, борлон, бяруунд зориулан нөөц бэлчээр болон үлдээдэг гэх зэрэг малын нас, хүйс, ашиглах зориулалтаас хамаарч бэлчээрийг тохируулан ашигладаг уламжлалтай. Эдгээр нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах заншлын хэм хэмжээний хүрээнд мөрдөгдөж ирсэн байна.

Сүүлийн жилд малын тоо хурдацтай нэмэгдэж, нүүдлийн мал ахуйг эрхлэх явцад хүрээлэн буй орчин, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх асуудал орхигдож нүүдлийн мал аж ахуйн уламжлал, заншлын хэм хэмжээний нөлөө буурч байна. Иймд бэлчээрийг ашиглах, хамгаалах уламжлалт сайн туршлагад тулгуурлах, нийтийн өмчийг үр ашигтай ашиглахад чиглэсэн орчин үеийн арга хэрэгслийг хослуулсан эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлага үүссэн байна.

Малын тоо толгойг цөөлөх, зохицуулах шаардлагатай тухай ихэнх малчид ярьж, санал бодлоо илэрхийлж буй ч юунаас эхлэх, даацаас хэтрээд байгаа малаа хэрхэх талаар ойлголт мэдлэг нимгэн байна. Бэлчээрийн ачааллыг бууруулах урамшууллын бодлогоос гадна малчдад мэргэжлийн зөвлөмж, дэмжлэг туйлын их шаардагдаж байна.

Иймд уг хуулийн төслөөр бэлчээр ашиглах уламжлалт арга барилыг боловсронгуй болгон хуульчлах шаардлагын хүрээнд бэлчээрийг ангилж, ангилал тус бүрт бэлчээрийн зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга замыг тодорхойллоо.

Мөн хуулийн төсөлд бэлчээрийг улирлын бэлчээр, отрын нөөц бэлчээр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээр гэж ангилсан. Улирлын бэлчээр, отрын нөөц бэлчээр, эрчимжсэн

мал аж ахуйн бэлчээрийг гэрээгээр ашиглуулна. Үүнд: улирлын бэлчээрийг бэлчээр ашиглалтад суурилан сэлгээ нүүдэл хийх, зохистой ашиглах, хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулсан, өөрийн дүрэмтэй малчин өрх, мал бүхий этгээдийн хамтын зохион байгуулалтын нэгдэл буюу “бэлчээр ашиглагчдын бүлэг”-т гэрээгээр ашиглуулна.

Отрын нөөц бэлчээрийг малчин, малчин өрхөд гэрээгээр ашиглуулж болох ба эрчимжсэн мал ахуйн бэлчээрийг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр ашиглуулж болох талаар заалт тусгалаа. Дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээрийг нийтээрээ ашиглахаар заана.

Бэлчээр ашиглалтын гэрээний үндсэн нөхцөл нь бэлчээрээ зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдыг үүрэгжүүлж талхагдал, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах явдал юм. Нийт бэлчээр нутгийн 65% доройтсон ч үүний 90% ачааллын тохируулж, ургамал ургалтын чухал үе шатанд сэлгэж амраавал байгалийн аясаар нөхөн сэргээх чадвараа хадгалж үлдсэн гэж эрдэмтэд судалгаагаар тогтоосон байна.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг нийт орон даяар 18 аймгийг хамруулан 2023 оны 04 дүгээр сарын 10-18-ны өдрүүдэд 5 бүс болгон зохион байгуулж, 960 гаруй малчид, мал бүхий иргэд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, орон нутгийн газар, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, аймаг, сум, багийн Засаг дарга нарын саналыг авлаа. Нийтдээ 20 гаруй чиглэлийн санал, хүсэлт ирүүлснийг тухай бүр задлан шинжилж хуулийн төсөл болон дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөлд тусгалаа.

Хэлэлцүүлгийн үед явуулсан санал асуулгын дүнгээс харахад нийт оролцогчдын 97,7 хувь нь бэлчээр доройтож байгаатай санал нийлсэн байна. Хууль, эрх зүйн орчныг өөрчлөх шаардлага байна уу гэсэн асуултад оролцогчдын 90,6 хувь нь заавал өөрчлөх хэрэгтэй гэж хариулсан байна. Бэлчээрийг хэрхэн ашиглах нь зөв бэ гэсэн асуултад 46 хувь нь гэрээгээр 27 хувь нь малын тоо толгойн албан татвараар гэж хариулсан байна.

Дээрх судалгааны дүнгээс харахад эдийн засгийн нэгэн тулгуур салбар болох мал аж ахуйг үндэсний хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхэд ул суурь нь болох бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг төрийн бодлого, нийгмийн болон байгалийн эрх ашигтай уялдуулан зохицуулах зорилгоор Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсрууллаа.

Бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулж доройтлоос сэргийлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилготой Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн төсөл нь 4 зүйлээс бүрдэнэ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бэлчээрийн ангилал, төрөл, нэр томьёог тодорхойлох, орон нутгийн байгууллага, бэлчээр ашиглагч, бэлчээр ашиглагчдын бүлгийн эрх үүрэг, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах үйл явц, бэлчээр ашиглах журам, бэлчээрийн төлөвлөлтийн тухай тусгасан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.3 дахь хэсэгт заасан зарчмын өөрчлөлт тусгагдаагүй бөгөөд Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт бэлчээрийг нийтээр болон гэрээгээр ашиглуулахаар заасныг нарийвчлан зохицуулахаар төслийг боловсруулсан тул хууль тогтоомжийн тандан судалгааны тайланг хийгээгүй болно.

Хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Малын Генетикийн нөөцийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Зөрчлийн тухай, Малын тоо, толгойн албан татварын тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

-----oOo-----

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.5.2.2-т “Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр шинэчлэн тогтоож малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого²-ын 8.3.3-д “Бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг тодорхой болгож, бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгож, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”³-ийн 3.3.5-д “Бэлчээрийн ашиглалт,

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2010 он, №

² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он, №25

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он, №38

хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын нийт газар нутгийн 70,1 хувийг⁴ бэлчээрийн газар эзэлж, энэхүү газар нутаг дээр манай улсын эдийн засаг, нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэдэг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл явагдаж байна Гэвч сүүлийн 30 жилийн хугацаанд бэлчээрийн газрын харилцаанд баримтлах бодлого хэт ерөнхий, зарчим тодорхой бус, эрх зүйн хүрээнд салбар дундын зохицуулалттай, бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих асуудал оновчгүй зэргээс улбаалан бэлчээрийн газрыг улирлын дагуу сэлгэн нүүдэллэж, хуваарьтай ашиглаж ирсэн олон мянган жилийн уламжлал алдагдаж, бэлчээрийн газрыг ашиглах асуудал эмх замбараагүй, хяналтгүй болж, бэлчээрийг сорчлон ашиглах, талхагдал, доройтол үүсгэхэд аливаа хүн хариуцлага хүлээхгүй байна.

Газрын тухай⁵ хууль тогтоомжид бэлчээрийн газрыг “нийтээр, дундаа ашиглах”-аар хуульчилсан зохицуулалт нь удаан хугацаандаа бэлчээр доройтуулах, талхлах, даац хэтрүүлэх үйлдэлд хариуцлага хүлээх эзэнгүй болгосон. Хяналтгүй, үнэгүй ашиглах боломжтой бэлчээрт малыг өсгөж, ашиг хүртэх сонирхол давамгайлж, малын тооны өсөлтөөр бэлчээрийн чадавхи, даацад ачаалал үүсгэхийн зэрэгцээ байгалийн жамаар бэлчээр нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна. Бэлчээрийн гарц сайтай эсхүл устай, зах зээлд ойр газарт олноор нүүдэллэн очиж, сорчлон ашиглаж, бэлчээрийн газрыг өнжөөж амраахгүйгээр даацаас хэтрүүлэн улирлын хуваарьгүй, ашиглаж байгаа өнөөгийн ашиглалт нь улмаар малчдыг нүүх,

⁴ Газрын нэгдмэл сангийн тайлан, 2021 он

⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №27

суух бэлчээргүй болгож, жилийн 4 улирлын туршид нэг газраа суурьших, ган, зудын үед нүүдэллэн очих нутаггүй, байгалийн дүрвэлт, газрын түрэмгийлэлд өртөхөд хүргэж байна. Мөн нийтээр ашиглах зохицуулалт нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй болгожээ.

Энэ нь цаашид Монгол Улсаас малын гаралтай органик бүтээгдэхүүн экспортлох боломжийг хязгаарлаж, улмаар монголчуудын түүх, соёл, өвийн салшгүй хэсэг болсон нүүдлийн ахуйт соёл иргэншил, уламжлалт өв соёл, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг улам бүр багасах эрсдлийг дагуулж байна. Үүний уршгаар нийт бэлчээрийн газар нутгийн 65.0 хувь доройтож, 13.0 хувь цөлжилтөд өртөөд байна.⁶ Хязгаарлагдмал нөөцийг хэмжээнээс хэтрүүлэн зохицуулалтгүй ашиглах нь өнөө болон ирээдүй хойч үеийн байгаль экологийн тэнцвэрт байдалд аюул учруулах билээ. Бэлчээр ашиглалтын ачааллын өнөөгийн горимыг зохицуулж чадвал нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаар сэргэх боломжтой⁷ гэж судлаачид үздэг.

Эрдэмтэд, судлаачдын тогтоосноор манай улсын бэлчээрийн хэвийн даац хонин толгойд шилжүүлснээр 86 сая мал байхад тохиромжтой гэж үздэг ч энэ үзүүлэлт 2022 оны жилийн эцсийн мал тоогоор тооцоход 120,7 саяд хүрсэн⁸ ба бэлчээрийн доройтлын түвшин аймаг, сум, баг тус бүрт харилцан адилгүй байна. Уул уурхайн замбараагүй хайгуул, олборлолтоос үүдэлтэйгээр малын бэлчээрийн газар өөр ангилалд шилжиж, малчдын өвөлжөө, хаваржааны газар, малын бэлчээр, хадлангийн талбайд цөмөрч мал бүхий иргэд, малчдын эрх

⁶ Газрын нэгдмэл сангийн тайлан, 2021 он

⁷ С.Цэрэндаш нар, УБ, 2006 он

⁸ <https://www.1212.mn>

ашигт хохирол учруулахын зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тасралтгүй урсгалын замын тоосжилтоос үүдэлтэйгээр хүн, малын эрүүл мэндэд шууд нөлөөлөх боллоо. Байгаль экологид учирч болзошгүйг эрсдлийн талаар Олон улсын мэргэжлийн байгууллагуудаас хийсэн судалгаануудад байгаль, цаг уурын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаа, төрийн оновчгүй бодлогоос улбаалсан бэлчээрийн газрын хөрсний үржил шимийн бууралт 2050 он гэхэд 3-4 дахинаар эрчимжих хандлагатай байна⁹ гэжээ.

Бэлчээрийн газар нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх суурь асуудал, хөгжлийн үндэс нь мөн тул түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг хариуцах этгээдийг тодорхойлох нь чухал юм. Бэлчээрийн газрын хил заагийг тогтоох зарчим зохицуулалтгүй, бэлчээр ашиглагчид болох малчин, мал бүхий иргэн, малчин өрх, тэдний хамтын зохион байгуулалтын хэлбэр, эрх зүйн статус тодорхойгүй, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын асуудал сумын газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгагддахгүй, бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтад төрийн оролцооны чиг үүрэг, хяналт тодорхойгүй, оновчтой бус байна. Түүнчлэн хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний эрэлт, хэрэгцээ, хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах шаардлагаас үүдэн эрчимжсэн мал аж ахуйг хот суурингийн орчимд хөгжүүлэх, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдэд зун, намар малаа бэлчээхтэй холбогдсон зохицуулалтыг бий болгох шаардлага байна. Малын тоо толгойг даацад тохируулах, бэлчээрийн ашиглалтыг зохицуулах шаардлагатайг малчид ойлгодог, ярьдаг ч юунаас эхлэх талаар шийдэл гаргаж чадахгүй байна. Сүүлийн 20 жилийн туршид бэлчээрийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааны эрх зүйг сайжруулах талаар хэлэлцсэн

⁹ Бэлчээрийн төлөв байддын тайлан

ч өнөө хүртэл шийдэлд хүрэхгүй байсаар дээрх сөрөг нөхцөл байдал хэдийнээ бий болчихлоо.

Иймд бэлчээрийн газрын ашиглалттай холбоотой практик дээр үүссэн нөхцөл байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой болгож, нарийвчлан оновчтой зохицуулах, төрийн өмчийн бэлчээрийн газрыг ашиглаж, хувийн өмчийн мал ахуй эрхэлж байгаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн өмчийн харилцаанд хоёр талын эрх үүргийн хэм, хэмжээг тогтоох, хариуцлагжуулах нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн, үүний дотор бэлчээрийн газрын доройтол, цөлжилтийг хязгаарлах үндсэн хөшүүрэг болохоор байна.

Дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлага нь бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбоотой харилцааг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нарийвчлан зохицуулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Газрын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд бэлчээрийг ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар 4 зүйлтэй бичигдэх бөгөөд төслөөр хуульд нэмж хэрэглэгдэх нэр томъёог тодорхойлж, бэлчээрийн зориулалт, ангилал, хил зааг, хэмжээ, байршлыг тогтоох, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, эдгээр үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох зэрэг харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөлд бэлчээрийг ашиглуулахдаа нийтээр болон гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зохицуулалтын заагийг тогтоож, нийтээр ашиглуулах бэлчээрт байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, уст цэг, хужир мараа бүхий бэлчээр болон дамжин өнгөрөх бэлчээрийг хамруулах,

гэрээгээр ашиглуулах бэлчээрийг улирлын бэлчээр, отрын нөөц бэлчээр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээрийг зориулалтын онцлог, ангилалаар зааглаж, бэлчээр ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойллоо.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зориулалт, ангиллын дагуу бэлчээр ашиглагчийн хүсэлт, холбогдох эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан ашиглуулах, бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд үндэслэн гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөлд гэрээт бэлчээрийг зохистой ашиглах, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах асуудлыг бэлчээр ашиглагч хариуцахаар, харин нийтээр ашиглуулах ангилалд хамаарах бэлчээрийн ашиглалт, сайжруулалт, хамгаалалтыг төр өөрөө хариуцахаар тусган боловсрууллаа.

Хуулийн төсөлд сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд улирлын бэлчээр, сумын отрын бэлчээр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр, байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, уст цэг, хужир мараа бүхий бэлчээр болон дамжин өнгөрөх бэлчээр гэж ангилан зохицуулахаар тусгалаа.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хил зааг, хэмжээ, байршлыг тогтоохдоо бэлчээрийн газар зохион байгуулалт, ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөг үндэслэн бэлчээр ашиглагчдын санал, багийн Иргэдийн нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах, гэрээг тухайн шатны Засаг дарга бэлчээр ашиглагч, бэлчээр ашиглагчдын бүлэгтэй байгуулж, гэрээ байгуулсан бэлчээрийн мэдээллийг газрын нэгдмэл сангийн тайланд тусгаж, газрын асуудал хариуцсан албан тушаалтан бүртгэдэг байхаар зохицууллаа.

Газрын нэгдмэл сангийн мэдээлэлд үндэслэн улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийг дайруулан Засгийн газар, орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийг хэмжээ, хилийн цэсийг аймгийн Засаг дарга тогтоохоор тусгах ба бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах журмыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан эрх бүхий этгээд батлахаар төсөлд тусган боловсрууллаа. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалтаар барилга, байгууламж барих, дэд бүтэц бий болгох тохиолдолд шаардлагатай газрыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тусгав.

Хуулийн төсөлд аймаг, сум, баг бүр нийт бэлчээрийнхээ 10-аас доошгүй хувийг отрын нөөц бэлчээрт авч байх, аймаг дундын бэлчээрийг хариуцан зохион байгуулах чиг үүргийг одоогийн бүтцийн чиг үүрэгт хариуцуулахаар хуулийн төсөлд тусгалаа. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг бэлчээрийн даацад нийцүүлэн хэлэлцэн шийдвэрлэх, харин сум дотроо нүүдэллэх бол тухайн сумын Засаг дарга шийдвэрлэх, гамшиг, аюулын тохиолдолд бэлчээр ашиглагчдын бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт бусдын мал оруулах асуудлыг гэрээний нөхцөлд тусгахаар заана.

Хуулийн төсөлд бэлчээрт ердийн хөрсөн зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бэлчээрийн эрүүл ахуйг алдагдуулах, малчдын саналыг үндэслэн ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаас бусад тохиолдолд инженерийн хийцтэй худаг гаргах, холбогдох зөвшөөрөлгүйгээр бэлчээрийн газарт ургамал түүх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр ашиглагчдын бүлэгт нүүлгэн шилжүүлэлтийн улмаас хохирол учруулахыг хориглох заалт тусгана.

Түүнчлэн хуулийн төсөлд тухайн шатны Засаг дарга бэлчээр ашиглуулах гэрээг бэлчээр ашиглагчдын бүлгийн саналыг харгалзан төрийг төлөөлөн байгуулахаар заана.-

Хуулийн төсөлд бэлчээр ашиглах, сайжруулах хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх үүрэг, бэлчээр ашиглах, хамгаалах үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулахаар заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлогт тохируулан, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд тулгуурлан бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалт, хамгаалалтыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин бүрдэнэ;

Бэлчээрийг нийтээр ашиглаж, хариуцлага хүлээдэггүй байдлыг зогсоож, бэлчээрт өөриймсөг хандаж, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах, хөрөнгө хүч зарж хамгаалах сэтгэлгээ төлөвшин, малын тоог өсгөх биш харин эдийн засгийн эргэлтэд оруулан борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээ бий болно;

Малчин өрх бүр улирлын болон отрын бэлчээртэй байх, бэлчээрээ хамгаалах, ашиглах эрх хөндөгдсөн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлдэг нийгмийн тэгш, шударга ёс хангагдах ба бэлчээрийн ангиллаас бусад ангилалд шилжихэд малчид,

нутгийн захиргаа, мал аж ахуйн салбарын эрх ашгийг зохистой харгалздаг нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Малын генетик нөөцийн тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай, Зөрчлийн тухай, Тариалангийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11-3.1.16 дахь заалт:

“3.1.11. “отрын нөөц бэлчээр” гэж гамшиг, аюулт үзэгдлийн үед болон нүүдэллэн оторлож ашиглах зориулалтаар эрх бүхий төрийн байгууллагаас тусгайлан тогтоож нөөцөлсөн газрыг;

3.1.12. “дамжин өнгөрөх бэлчээр” гэж мал тууварлах, нүүдэллэхэд зориулсан зурвас бэлчээрийг;

3.1.13. “бэлчээрийн даац” гэж бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн чадавхийг тогтоосон үзүүлэлтийг;

3.1.14. “бэлчээр ашиглагч” гэж малчин өрх, мал бүхий этгээд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг;

3.1.15. “бэлчээр ашиглагчдын бүлэг” гэж энэ хуулийн 11.3-т заасан бэлчээр ашиглалтад суурилан сэлгээ нүүдэл хийх, зохистой ашиглах, хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулсан, өөрийн дүрэмтэй малчин өрх, мал бүхий этгээдийн хамтын зохион байгуулалтын нэгдлийг;

3.1.16. “малчин өрх” гэж жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг.”

2/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“6.5.Энэ хуулийн 11.2.1-11.2.3-т заасан бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулна.”

3/11 дүгээр зүйлийн 11.2-11.8 дахь хэсэг:

“11.2.Бэлчээрийн газрыг дараах байдлаар ангилна:

11.2.1.улирлын бэлчээр;

11.2.2.отрын нөөц бэлчээр;

11.2.3.эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр;

11.2.4.дамжин өнгөрөх бэлчээр;

11.2.5.байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээр.

11.3.Энэ хуулийн 11.2.1-т заасан бэлчээрт өвөл, хавар, зун, намрын улиралд ашиглах бэлчээрийн газар хамаарна.

11.4.Отрын нөөц бэлчээрт аймаг, сум, сум дундын, багийн отрын бэлчээрийн газар хамаарна.

11.5.Энэ хуулийн 11.2.1-11.2.3-т заасан бэлчээрийн газрыг гэрээгээр, 11.2.4, 11.2.5-д заасан бэлчээрийн газрыг нийтээр ашиглуулна.

11.6.Энэ хуулийн 11.2.1--т заасан бэлчээрийн газрыг энэ хуулийн 3.1.15-д заасан бүлэгт гэрээгээр ашиглуулна.

11.7.Энэ хуулийн 11.2.2-т заасан бэлчээрийн газрыг малчин, малчин өрхөд гэрээгээр ашиглуулж болно.

11.8.Энэ хуулийн 11.2.3-т заасан бэлчээрийн газрыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр ашиглуулж болно.”

4/18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт

“18.1.8.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймаг дундын отрын нөөц бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тогтоох.”

5/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.3.1.бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

19.3.2.аймаг дундын дамжин өнгөрөх бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулах байршилтай уялдуулан тогтоох;

19.3.3.бэлчээрийн газрын төлөв байдал, даацад тохируулан аймаг дундын отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, мал оруулах, малаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх;

19.3.4.бэлчээрийн газрын даац тогтоох аргачлал батлах.”

6/20 дугаар зүйлийн 20.1.6 - 20.1.9, 20.2.10 - 20.2.19 дэх заалт:

“20.1.6.тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журам батлах;

20.1.7.бэлчээр ашиглагчдын саналыг үндэслэн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал улирлын бэлчээр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, отрын нөөц бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тогтоох;

20.1.8.сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сум дундын отрын нөөц бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох;

20.1.9.багийн иргэдийн Нийтийн Хурал, сумын Засаг даргын санал, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн сумын отрын нөөц бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг холбогдох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох;

20.2.10.бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн санал, багийн Иргэдийн Нийтийн Хурал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн Засаг дарга энэ хуулийн 11.2.1-11.2.3-т заасан бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах;

20.2.11.сум дундын отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, мал оруулах, чөлөөлөх асуудлыг холбогдох сумын Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга шийдвэр гаргах;

20.2.12.шинээр өрх тусгаарласан болон шилжиж ирсэн малчин өрхийг бэлчээр ашиглагчдын бүлгийн саналыг харгалзан бэлчээрийн даацад тохируулан сумын Засаг дарга тухайн бүлэгт оруулах шийдвэр гаргах;

20.2.13.баг, сумын отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, мал оруулах, чөлөөлөх асуудлыг багийн Засаг даргын саналыг үндэслэн сумын Засаг дарга шийдвэр гаргах;

20.2.14.аймаг, сум дамжин өнгөрөх бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган тухайн шатны Засаг дарга тогтоох;

20.2.15.сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан бэлчээрийн газрыг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, отор нүүдэл хийх сар, улирлын хуваарийг батлах;

20.2.16.газрыг цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрт мод, бут сөөг, олон наст ургамал тарих, бууцаар бордох, хаших зэрэг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах ажлыг зохион байгуулах;

20.2.17.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малыг бэлчээрийн даацад тохируулан түр хугацаагаар нутаг дэвсгэртээ оруулах;

20.2.18.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрийн бэлчээрт мал оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг дарга хамтран шийдвэрлэх;

20.2.19.энэ хуулийн 20.2.18-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэх.”

7/21 дүгээр зүйлийн 21.4.4 дэх заалт

“21.4.4.өвөлжөө, хаваржааны бэлчээрийн газрыг зун, намрын улиралд малаас чөлөөлөх хугацааг мөрдүүлэх;

8/22 дугаар зүйлийн 22.1.4, 22.2.4 дэх заалт

22.1.4.бэлчээрийг дундаа хамтран ашиглаж, сэлгээ нүүдэл хийж ирсэн уламжлалд суурилан зохион байгуулагдах бэлчээр ашиглагчдын бүлгийн гэрээгээр ашиглах бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлын талаарх малчдын саналыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх.

22.2.4.сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, отор нүүдэл хийх сар, улирлын хуваарийг мөрдүүлэх;

9/23 дугаар зүйлийн 23.4.7-23.4.9 дэх заалт:

“23.4.7.энэ хуулийн 11.2-т заасан бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлын зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх;

23.4.8.энэ хуулийн 23.4.7-д заасан бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тухайн жилийн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

23.4.9.энэ хуулийн 11.2.1-д заасан бэлчээрийн газрыг бэлчээр ашиглагчдын бүлэгт гэрээгээр ашиглуулах газрын хил зааг, хэмжээ, байршлыг зургийг үйлдэх;

23.4.10.бэлчээрийн төлөв байдлыг тогтоох, бэлчээрийн төлөв байдлын фотомониторингийн үнэлгээг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг бүртгэх, биелэлтийг жил бүр дүгнэх.”

10/29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэг:

“29.7.Багийн Иргэдийн нийтийн хурлын санал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчин өрхөд өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1.0 га хүртэлх газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлж болох ба тухайн газарт малын тэжээл тариалж болно.

11/53 дугаар зүйл:

“53 дугаар зүйл. Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар бэлчээр ашиглагчийн эрх, үүрэг

“53.1.Бэлчээр ашиглагч, бэлчээр ашиглагчдын бүлэг дараах нийтлэг эрх эдэлнэ:

53.1.1.бэлчээрийн газрыг хууль болон гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах;

53.1.2.бэлчээр ашиглагчдын бүлэгт орох, бүлгээс гарах;

53.1.3.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг бусад этгээд зөвшөөрөлгүй, дур мэдэн ашигласан тохиолдолд уг үйлдлийг зогсоохыг шаардах, шаардлага биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;

53.1.4.бэлчээрт учруулсан аливаа хохирлыг тогтоолгох, нөхөн төлүүлэх.

53.2.Бэлчээр ашиглагч, бэлчээрийн ашиглагчдын бүлэг дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

53.2.1.энэ хуулийн 52.4-т заасан гэрээний үүргээ биелүүлэх;

53.2.2.бэлчээрийн даацад малын тоог тохируулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

53.2.3.сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийн газрыг сэлгэх, өнжөөх, улирлаар нүүх хуваарийг мөрдөж, тогтоосон хугацаанд мал оруулах, гаргах;

53.2.4.өвөлжөө, хаваржааны бэлчээрт зун, намрын улиралд мал оруулахгүй хамгаалах, бэлчээрийг доройтуулахгүй байх, хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээ авах;

53.2.5.дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн тогтцоор бий болсон хужир мараа, уст цэг бүхий бэлчээр, зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулж өвөлжөө, хаваржааны барилга байгууламж, хашаа саравч барихгүй, суваг, шуудуу ухахгүй байх;

53.2.6.хөрш болон саахалт малчид, малчин өрх, мал бүхий этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

53.2.7.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бэлчээрийн газарт учруулсан хохирлыг нөхөн төлөх;

53.2.8.бэлчээрийн газрын хөрсийг эвдэхгүй, хөрс, усыг бохирдуулахгүй, хог хаягдал хаяхгүй байх;

53.2.9.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр ашиглаж байгаа

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл

бэлчээрийн газарт эрх бүхий этгээдээс баталсан хуваарийн дагуу мал оруулах, гаргах;

53.2.10.түүх соёлын өв, зэрлэг амьтдыг хамгаалах арга хэмжээ авах.”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалт, 52 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалт:

“6.2.1.дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн тогтцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээр;”

2/52 дугаар зүйл:

“52 дугаар зүйл. Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

52.1.Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг энэ хуульд заасан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний баримт бичигт үе шаттайгаар төлөвлөж, хэрэгжүүлнэ.

52.2.Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд бэлчээр ашиглагчдын бүлэг, бэлчээр ашиглагчийн оролцоо, эрх тэгш байдлыг хангана.

52.3.Аймаг, сум, багийн бэлчээрийн 10-аас доошгүй хувь нь отрын нөөц бэлчээр байна.

52.4.Энэ хуулийн 11.2.1-11.2.3-т заасан бэлчээрийн газрыг ашиглуулах гэрээнд дараах зүйлийг тусгана:

52.4.1.бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах талаарх Засаг даргын шийдвэр;

52.4.2.бэлчээр ашиглагчдын бүлэг болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч этгээдийн оноосон нэр;

52.4.3.хил зааг, хэмжээ, байршил;

52.4.4.гэрээний хугацаа;

52.4.5.талуудын эрх үүрэг, хариуцлага;

52.4.6.бэлчээрийн даац, бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа;

52.4.7.бэлчээрийн газрыг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх төлөвлөлт;

52.4.8.энэ хуулийн 11.2.1-11.2.3-т заасан бэлчээрт гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бусдын малыг оруулах;

52.4.9.бусад.

52.5.Шинээр өрх тусгаарлаж байгаа болон шилжиж ирсэн малчин өрхийг гэрээ байгуулсан бүлэгт оруулах, даацад тохируулан бэлчээрийг хамтран ашиглах, хамгаалах шийдвэрийг тухайн бэлчээр ашиглагчдын бүлэг гаргана.

52.6.Энэ хуулийн 52.3-т заасан газрыг гэрээгээр ашиглуулах хугацаа 15 жилийн хугацаатай байх бөгөөд бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд үндэслэн анх гэрээ байгуулсан хугацаагаар сунгаж болно.

52.7.Энэ хуулийн 11.1-д заасан бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг энэ хуулийн 20.1.6-д заасан журмаар зохицуулна.

52.8.Энэ хуулийн 20.2.18, 20.2.19-т заасны дагуу мал оруулсан хугацааны бэлчээр ашиглалтад ногдох албан татварыг Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6.2-т тогтоосон хэмжээгээр малаа оруулсан сум, дүүргийн төсөвт төлнө.

52.9.Бэлчээрийн газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

52.9.1.сумын Засаг даргын шийдвэргүйгээр бэлчээр ашиглагч, бэлчээр ашиглагчдын бүлэг шинээр өвөлжөө, хаваржаа барих;

52.9.2.бэлчээр ашиглагч, бэлчээр ашиглагчдын бүлэг энэ хуулийн 11.2-т заасан бэлчээрийн газрыг хаших;

52.9.3.энэ хуулийн 11.1-д заасан бэлчээрийн газарт барилга байгууламж холбогдох хууль тогтоомжид заасан зөвшөөрөлгүйгээр барих, худалдах;

52.9.4.ердийн хөрсөн зам гаргах, хөрсийг эвдэх, бохирдуулах, бусад байдлаар газрын төлөв байдал, чанарыг бууруулах;

52.9.5.холбогдох хуульд заасан зөвшөөрөлгүйгээр эмийн болон ховор ургамал, байгалийн өнгөт болон үнэт, эрдэнийн чулуу түүх;

52.9.6.сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаснаас бусад тохиолдолд инженерийн хийцтэй худаг гаргах;

52.9.7.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэ хуулийн 19.3.4-д заасан аргачлалаар бэлчээрийн даац хүрэлцээтэйг тогтоосон байтал мал оруулахаас татгалзах

52.9.8.малчин өрхийг уул уурхайн хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас нүүлгэн шилжүүлэх тохиолдолд уг үйл ажиллагаа эрхлэгч этгээд холбогдох төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.”

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн “53-64” дүгээр зүйлийн дугаалалтыг “54- 65” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2024 оны ... сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/21 дүгээр зүйлийн 21.1.17 дахь заалт:

“21.1.17.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт;”

2/22 дугаар зүйлийн 22.1.22 дахь заалт:

“22.1.22.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт;”

3/35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт:

“35.1.17.Газрын тухай хуульд заасан бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тогтоох, бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журам батлах;”

4/60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт:

“60.1.20.Газрын тухай хуульд заасан бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тогтоох, бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалттай холбоотой шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 58.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“58.1.13.Газрын тухай хуульд заасан бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хадлангийн болон тариалангийн талбай, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.1.5, 59.1.13 дахь заалтын “бэлчээр” гэснийг “бэлчээрийн газрыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг хангах” гэж, мөн хуулийн 27.5.11 дэх заалтын “менежмент” гэснийг “ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт” гэж, “60.1.21”, “35.1.17” гэсэн дугаарлалтыг “60.1.22.”, “35.1.17” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтын “бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон” гэснийг “бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын фотомониторингийн үнэлгээ хийх, бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилт, хяналтыг зохион байгуулах, малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“6.Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журам зөрчсөн, бэлчээр ашиглагчийн нийтлэг үүргийг биелүүлээгүй, эсхүл бэлчээрт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

1/16 дугаар зүйлийн 16.8.9-16.8.12 дахь заалт:

“16.8.9.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах, малын тэжээл, усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг сурталчлах, тайлагнах;

16.8.10.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт бэлчээрийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулах, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээнд хяналт тавих, үр дүнг сурталчлах, тайлагнах;

16.8.11.бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлыг тогтооход санал өгөх, орон нутгийн онцлогт тохируулан бэлчээрийн менежментийг сайжруулах саналыг хэлэлцүүлэх, бэлчээрийн даац, ургац тогтоох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

16.8.12.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын болон ус, цаг уур орчны асуудал хариуцсан төрийн байгууллагатай бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтран ажиллах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг хянах, тайлагнах.”

2/16 дугаар зүйлийн 16.9.9-16.9.12 дахь заалт:

“16.9.9.сум, дүүргийн нутаг дэвсгэрт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах, малын тэжээл, усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг сурталчлах, тайлагнах;

16.9.10.сум, дүүргийн нутаг дэвсгэрт бэлчээрийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг сум, дүүрлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулах, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээнд хяналт тавих, үр дүнг сурталчлах, тайлагнах;

16.9.11.бэлчээрийн газрын хил зааг, байршил, хэмжээг тогтоох, орон нутгийн онцлогт тохируулан бэлчээрийн менежментийг сайжруулах саналыг хэлэлцүүлэх, бэлчээрийн даац, ургац тогтоох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

16.9.12.сум, дүүргийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын журмыг боловсруулах, хэлэлцүүлэх, бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах, эзэмшүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих ажлыг газрын даамалтай хамтран хэрэгжүүлэх, уг үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.”

2 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн “16.6 дахь хэсгийн “мал зүйч” гэсний дараа “бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.5 дахь хэсэг нэмэх:

1/7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:

“7.5.Албан татвар төлөгч гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргээс өөр сум, дүүргийн нутаг дэвсгэрт малаа сэлгэн нүүдэллэсэн тохиолдолд энэ хуулийн 6.2-т заасан хэмжээгээр албан татварыг сэлгэн нүүдэллэсэн сум, дүүргийн төсөвт төлнө.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИЛЖИЛТ, ТАЛХАГДАЛ, ЦӨЛЖИЛТ.

Бэлчээрийн талхагдал ба байгалийн аясаар нөхөн сэргэх чадвар.

Монгол орны МАА-н салбарын хөгжил нэн эгзэгтэй мөчид тулж ирээд байна. Газрын улсын нэгдмэл сангийн 2022 оны тайлангаас үзэхэд Монгол орны газар нутгийн 70.1% хувийг эзэлдэг 110.0 сая га бэлчээр нутгийн зөвхөн 12.4% эрүүл соргог байна. Үлдсэн 87.3% -ийн төлөв байдал ямар нэгэн байдлаар өөрчлөлтөд оржээ. Үүний 57.0 сая га буюу 52.3%-ийн ургамлын төрөл зүйлүүд өөрчлөгдөж, малд идэмжтэй олон наст үет ургамлын хувь хэмжээ буурч, идэмж муутай болон ашиггүй хөл газрын ургамлын эзлэх хувийн жин нэмэгдсэн байна.


Эдгээр бэлчээрийг сэлгэж амраахгүй бол цаашид доройтол нь улам гүнзгийрэх хандлагатай байна. 15.7 сая га буюу 14.4% бэлчээрт хүчтэй доройтлын шинж тэмдэгүүд илэрчээ. Ургамлын төрөл зүйлийн ихэнх хувь нь малд идэмжгүй, халцгай газрын хэмжээ тэлсэн, нөхөн сэргэхэд 5-10 хүртэлх жилийн хугацаа орно. Энэ хугацаанд урт хугацаагаар амраах, байгалийн ургамалд нөхөн төлжих хугацаа тавьж өгөх, малын хөлөөс тодорхой хугацаанд чөлөөлөх шаардлага гарч байна. Нийт нутаг бэлчээрийн 5.6 сая га буюу 5.1% нь маш хүчтэй доройтож цөлжсөн байна. Эдгээр бэлчээрийн байгалийн аясаар нөхөн сэргэх чадвар нь аль хэдийн устжээ.

Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал.

Сэргэх чадварын ангилал	Шалгуур
Түвшин I	Ургамлын бүрэлдэхүүн лавлагаа төлөв байдал (талхлагдаагүй)-тай бараг ойролцоо, бага зэрэг доройтсон төлөв байдлаас лавлагаа төлөв байдалд шилжихэд ургалтын 1-3 улирал шаардагдах, ашиглалтын эрчим (ачаалал) тэжээлийн нөөц (даац)-тэй үндсэндээ дүйж байгаа, түүнчлэн улирлаар сэлгэж ашиглах шаардлагатай.
Түвшин II	Ургамлын бүрэлдхүүн сөрөг тал руу бага зэрэг өөрчлөгдсөн, хур тунадас боломжийн байх, эсвэл ашиглалтын хэлбэр (ачааллыг бууруулах, улирлаар сэлгэх, түр амраах)-ийг зохистой өөрчилж чадсан тохиолдолд богино хугацаа (ургалтын 3-5 улиралд)-д сэргэх боломжтой. Өөрчлөлт нь урт хугацаанд бэлчээрийн тэжээлийн хангамж, экосистемийн бусад үйлчилгээнд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрээгүй, тийнхүү үнэлэх үндэслэлгүй.
Түвшин III	Ургамлын бүтэц, бүрэлдхүүн нэлээд өөрчлөгдсөн, ашиглалтын арга хэлбэр (ачааллыг бууруулах, улирлаар сэлгэх, түр амраах)-ийг шаардлагатай хэмжээнд өөрчилж чадсан тохиолдолд ургалтын 5-10 улиралд сэргэх боломжтой. Өөрчлөлтийн улмаас экосистемийн зарим чухал үйлчилгээ алдагдсан, гэхдээ цаг хугацааны тодорхой эргэлтэд сэргэх боломж бий.

Түвшин IV	Зонхилох зүйл ургамал устаж, хортой болон ашиггүй зүйл ургамал хүчтэй түрж түүнчлэн усзүйн горим өөрчлөгдсөний улмаас эргэж нөхөн сэргэнэ гэх найдвар тун бага, харин үр хачирлах, түрэгч ургамлыг устгах, усны горимыг дахин сэргээх замаар 10, түүнээс дээш жилээр эрчимтэй ажиллагаа явуулбал сэргэж болзошгүй (босго утгаа давж доройтсон). Экосистемийн үндсэн үйлчилгээ бүрмөсөн алдагдсан, эргэж сэргээхэд маш их хөрөнгө зардал шаардана.
Түвшин V	Хөрсний хүчтэй алдагдал, эрчимтэй явц бүхий элэгдэл, давсжилтын улмаас ургамлын бүрэлдхүүн бүхэлдээ өөрчлөгдсөн Ургамал-хөрсний харилцан хамаарал, үйлчлэл болон хөрсний шинж чанар үлэмж хэмжээгээр доройтож өөрчлөгдсөн нь доройтлын төлөв байдал арилахгүй хадгалагдах гол нөхцөл болж байгаа. Экосистемийн үндсэн үйлчилгээ бүрмөсөн алдагдсан, нөхөн сэргээх боломж үндсэндээ байхгүй (жинхэнэ цөлжсөн гэж үзэх үндэслэлтэй).

Зураг 1. Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт.




Бэлчээрийн талхагдлын үндсэн шалтгаанууд.

2022 оны байдлаар Улсын хэмжээнд бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр 82.0 сая мал өвөлжиж, хаваржих боломжтой байна. Жилийн эцсийн малын тоо 117.0 сая хонин толгой байгаа ба энэ нь боломжит даацаасаа 35.0 сая хонин толгойгоор хэтэрсэн байна.

Байгалийн энэхүү зүй тогтол газрын хөрсний шим тэжээл, бэлчээрийн ургац, ургамал, бүтээмжид ч мөн адил үйлчилдэг. Бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглана гэдэг нь хөрснөөс дээш цухуйсан ургамлын навч найлзуурыг нөхөн төлжих чадваргүй болтол нь идэж дуусгаснаас ургамлын үндэс нь үхжиж, бүрмөсөн устана гэсэн үг. Бэлчээрийн даац хэтэрсэн нутаг орны ургамал, хөрс хэрхэн доройтож, улмаар устаж үгүй болдог зүй тогтлыг эрдэмтэд ийнхүү тогтоожээ.

Бэлчээрийн ургамал хэт их ашиглалтын нөлөөгөөр хэрхэн доройтож устаж байгаа зүй тогтол



Жонсон, 1961

Дээрх зурагт харуулснаар бэлчээрийн ургамлын навчны ашиглалт 50 хүртэл хувь байхад үндэс нь бараг гэмтэхгүй, хамгийн ихдээ 2-4 хувь гэмтэх магадлалтай бол 50-аасдээш хувиардавуулан ашиглахад үндэсний гэмтэл маш хурдацтай

явагддаг байна. Үүнийг эрдэмтэд талыг нь идээд талыг нь байгальд нь үлдээх зарчим ч гэж бас нэрлэдэг. Уншигчид маань санаж байвал дунд сургуулийн ургамал зүйн хичээлд заадагчилан, хөрсний дээрх ургамал ногоо нь хөрсөн дэх ус чийгийн тусламжтайгаар нарны илч гэрэл, агаар дахь нүүрс хүчлийн хийг өөртөө шингээн нөхөн үржих шим тэжээлээ авдаг. Хэрвээ ургамлын навч найлзуурыг тасдаж гэмтээх явдал дээрх 50/50 харьцаанаас хэтэрвэл фотосинтез явагдахаа больж, ургамал нь шим тэжээлээр дутагдан, хэсэгхэн хугацаанд үндэснийхээ суурь шимээр тэжээгдэх боловч, улмаар үндэс нь мөн сульдаж, үхжиж эхэлдэг байна.

Эсрэгээрээ, хөрснөөс цухуйж гарсан ургамлын 50%-иас дээшгүйг малд идүүлж, үлдсэн 50%-ийг хөндөхгүй үлдээж чадвал ургамал нөхөн төлжих чадвараа хадгалсаар байдаг. Өөрөөр хэлбэл, хөрс нь бүрхүүл ургамлын навч найлзуураар дамжуулан үржил шимээ авч нөхөн төлждөг тул дээрх харьцааг баримтлах буюу бэлчээрийн ургацыг шавхан ашиглахгүй байх нь хөрсийг өөрийг нь хамгаална гэсэн үг юм. Тийм учраас байгалийн хөрс, ургамлыг хамгаалах, талхагдуулахгүйн тулд хөрсөн дээрх ургамлыг ашиглах зохистой харьцааг баримталж, малын тооны ачааллыг зохицуулах, бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглахгүй байхын чухлыг дэлхийн олон орны эрдэмтэд онцлон хэлж захисаар иржээ.

Олон арван жилийн турш бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглаж, талхагдуулсан нь цөлжилтийг улам эрчимжүүлэхэд хүргэж байна. Ургамлан нөмрөггүй болсон хөрс салхи шуурга, үер усны нөлөөгөөр эвдрэлд орон эмзэг болж, хөрсний үржил шимт өнгөн хэсэг нь угаагдан хийсч, сарниж алга болсоор байна. Хөрсний дээд хэсгийн ургамал хамгаалалт болдог. Ургамлан нөмрөг байхгүй бол хөрсний гадарга дээр буусан нарны гэрэл хөрсний хур чийгийг хатааж, ямар ч хамгаалалтгүй

болсон хөрс салхи усны нөлөөнд хялбархан гэмтэж, эвдрэлд орно. Салхи, усанд элэгдсээр газрын хэвлийд гүнзгий гуу жалга, эрэг шуудуу үүснэ. Хөрс, ургамал эх байгалиас заяасан нөхөн төлжих чадвараа нэгэнт алдах тэр үе шатыг “босгоо давах” гэж шинжлэх ухаанд нэрлэдэг. Энэ босгыг давсны дараа ургамал, түүний хөрс өөрийн нөхөн төлжих чадвараа бүрмөсөн алдлаа гэсэн үг. 10 см үржил шимт хөрс байгальд бий болоход 2000 жилийн хугацаа ордог. Ийм л учраас байгалиас заяасан хөрс, ургамлын нөхөн сэргэх чадварыг хадгалахын чухлыг эрдэмтэд сануулсаар ирсэн байна.

Бэлчээрийн талхагдал ахисаар нөхөн сэргэх чадавхиа алдах буюу “босгоо давах” цөлжих зүй тогтол



Бэлчээрийн хөрс талхагдаж нягтарснаар ус, чийг, агаар нэвтрүүлэх горим алдагдана. Энэ нь ургамлын үндэсний өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж эхэлнэ. Бэлчээр соргог байх үед нэг га-д найман тонн үндэс агуулагддаг байсан бол талхагдсан бэлчээрт түүнээс хоёр дахин бага буюу дөрвөн тонн болдгыг эрдэмтэд тогтоожээ. Мөн хөрсний ус нэвтрүүлэх чадвар буурч


хур борооны ус хөрсөнд шингэхгүй, газрын гадарга дээгүүр урссанаар хөрс, усанд угаагдаж эвдэрдэг байна.

Соргог бэлчээрийн газрын хөрсний ус нэвтрүүлэх чадварыг шинжилж үзэхэд, 141.9 мм цаг байгаа бол талхагдсан бэлчээрийнх 70.8 мм цаг болж хөрсний ус нэвтрүүлэх чадвар хоёр дахин буурсан байна. Тал хээрийн соргог бэлчээрийн сүвшилт (агаар, ус нэвтрүүлэх) 3-7 см-ийн гүнд 56 хувь, 12-16 см-ийн гүнд 55.2 хувь байгаа бол талхагдсан бэлчээрийнх 3-7 см-ийн гүнд 53.7 хувь болж хөрсний өнгөн үеийн сүвшилт 4.1 хувиар буурсан байна. Бэлчээрийн газар талхагдалд орсноор хөрсний сүвшилт буурч байгаа нь газрын доройтлын нэг шинж юм. Мөн хөрсний бүтэц, бүхэлшилт багасч, илүү тоосорхог болон салхи усны эвдрэлийг тэсвэрлэх чадвар буурна.

Хөрсөн доторх нэг мм-ээс том хэсгийн эзлэх хувийн жин бага багаар буурна гэсэн үг. Ийнхүү бэлчээрийн хөрсний бүтэц аажмаар алдагдсанаар салхи, усны эвдрэлд улам бүр эмзэг болж цөлжинө. Манай Монголын нийт бэлчээрийн 78 хувь хөрсний элэгдэлд өртсөн гэж эрдэмтэд тогтоожээ. Үүний үндсэн шалтгаан бидний ярианы гол сэдэв болсон бэлчээрийн даац хэтрэлт буюу бэлчээрийн талхагдал мөнөөс мөн. “Дөрвөн цагийн улиралд дураараа нүүдэллэх нутагтай” гэж шүлгэнд хүртэл гардаг нутаг маань зөвхөн түүх болж үлдэх вий дээ. Талын Монгол-Цөлийн Монгол болох хамгийн бүрхэг ирээдүйг ойртуулж буйг анхаарах цаг аль хэдийнээ болжээ.

Дээрх зүй тогтлоос бид бэлчээрийн даац хэтэрсэн аймаг сумдын нутагт ургамлын үндэс доройтож, улмаар устаж үгүй болох аюул нүүрлээд буйг шууд ажиглах боломжтой. Энэ үзэгдэл сүүлийн 20 гаруй жилийн турш Монгол оронд үргэлжилсээр байна. Малчид ч өөрсдөө малд идэмжтэй, тэжээллэг өвс ургамлын гарц, төрөл зүйл жил ирэх тусам буурсаар байгаа тухай ярьдаг.

Бэлчээрийн боломжит даац ба малын тоо 2022 он



Өнөө үед бэлчээрийг төлөвлөгөө, зохицуулалтгүй ашиглаж байгаа нь байгалийн ургамалд нөхөн төлжих хугацаа, боломж олгохгүй байна. 1990-ээд оноос өмнө бэлчээр ашиглалтыг их нарийн төлөвлөдөг байжээ. Жишээ нь, 1980-аад оны хүн амын хүнсний хэрэгцээ, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, 2000 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө гаргахдаа бэлчээрийн даацын норм нормативыг тооцон зун намар 87.4 сая хонин толгой буюу таван төрлөөр 24 сая орчим, өвөл хаварт үүнээс бараг хоёр дахин бага 49.9 сая хонин толгой мал бэлчээр тэжээх бололцоотой гэж гаргаж байжээ.

Ингэхдээ 1960-1970-аад оны 10 жилийн судалгааны бүрэн хэмжээний дүгнэлт дээр үндэслэн тогтоосон байдаг. Гэтэл бэлчээрийн талбайн хэмжээ тэр үеийнхээс 20 сая га-гаар багасаад бэлчээрталхагдсаны улмаас бүтээмж нь хэд дахин буурсан одоо үед таван төрлөөр 66.2 сая толгой, хонин толгойд

шилжүүлснээр 110.2 сая болсон байдаг. Доктор С.Цэрэндаш нар тэргүүтэй эрдэмтдийн 2000 онд хийсэн судалгаанд өнтэй жил дунджаар 86 сая гаруй хонь, харин урьд зун нь гантай жил 57 саяас хэтрүүлэхгүй байх, өөрөөр хэлбэл 100 га бэлчээрийн талбайд 62 хонь бэлчээрлүүлэх экологийн даацтай гэж тооцсон байна.

Бэлчээр нутгаа зөв эдлэхэд баримтлах 4 үндсэн дүрэм:

Байгалийн бэлчээрт хайр гамгүй хандаж буруу ашигласнаас учрах хохирол хязгааргүй юм. Манай малчдын үе уламжилж ирсэн баялаг туршлага, судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан бэлчээрийг системтэй ашиглахад баримтлах учиртай 4 үндсэн дүрэм байна.

Нэгдүгээр дүрэм. Бэлчээрийн даацыг үл хэтрүүлэх

Бэлчээрийн даац нь тодорхой хугацаанд нэг га бэлчээрт бэлчээрлүүлж болох малын тоог хэлнэ. Тодорхой нэг бэлчээр нутагт хичнээн тооны малыг хэдий хугацаанд маллаж болохыг заасан үзүүлэлтийг бэлчээрийн багтаамж гэнэ. Бэлчээрийн даац, багтаамжийг хэтрүүлэхгүй байх нь малчин хүний ямагт чанд баримтлах дүрэм юм.

Хоёрдугаар дүрэм. Бэлчээрийн тэжээлийн нөөцийг үл шавхах дүрэм

Бэлчээрийн ургацыг 50 хувиас хэтрүүлэн ашиглаад байвал уг бэлчээр амархан доройтно. Иймд бэлчээрийн тэжээлийн нөөцийг барагдуулахгүйн тулд улирал бүрийн нүүдэл суудал, малын хариулга, маллагааг сайн зохион байгуулж чадвал бэлчээр сэргээд ирдэг.

Гуравдугаар дүрэм. Бэлчээрийн ургамалд нөхөн төлжих хугацаа тавьж өгөх дүрэм

Ургамлыг тасалж идүүлсний дараа уг ургамалд төлжиж ургахад тодорхой хугацаа шаардлагатай болно. Ургамлыг дөнгөж ургаж эхэлмэгц дахин дахин малд идүүлээд байвал уг ургамлын үндэс суларч, нөөцөө шавхсаар эцэстээ өвлийн хүйтэн, гандалтыг даахгүй үхээд өгнө.

Дөрөвдүгээр дүрэм. Бэлчээрийг сэлгэж байх дүрэм

Бэлчээрээ доройтуулахгүйн тулд ашиглалтын хугацаа болон ашиглах эрчмийг харгалзан жил жилээр сэлгэж ашиглана.